



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 69

Номгон

**Өлзийт сумын сургуулийн дотуур байрны
барилгыг данснаас хасч, худалдах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9.2, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит 14 дүгээр хуралдааны 14/6 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Өлзийт сумын сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 1972 онд ашиглалтад орсон 50 хүүхдийн дотуур байрны 1 давхар барилгыг орон сууцны зориулалтаар худалдаж үндсэн хөрөнгийн бүртгэлээс хассугай.

2. Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын дарга /М.Зоригт/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг зөвлөсүгэй.

2.1 Барилгын 1м² талбайн худалдах үнийг газрын хамт худалдах доод үнийг 50,0 /тавин мянган/ төгрөгөөр тогтоож хамт олны шийдвэрийг харгалзан 10 жилээс дээш жил тус байранд амьдарсан сургуулийн өндөр настан, ахмад багш, ажилчинд худалдах;

2.2 Газар барилгын худалдсанаас орох орлогыг сумын Орон нутгийн төсөвт 2019 оны 07 дугаар сарын 17-ны дотор төвлөрүүлэх;

3. Худалдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, санхүүгийн програмаас хасалт хийхийг Өлзийт сумын сургуулийн захирал /Ө.Хашбилэг/-д даалгасугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтийг 2019 оны 08 дугаар сард багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлэхийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Идэрмөнх/-д даалгасугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР